



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 4/525

Улаанбаатар хот


Гадаад сургалт зохион байгуулах,
зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.23 дах заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1, 14.2.3, 14.2.5 дах заалт, Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2014 оны 119 дүгээр тушаалаар баталсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ын 1.5 дах заалт, Сангийн сайдын "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 2011 оны А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багийн эмч нарыг чадавхижуулах сургалтыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд зохион байгуулсугай.
2. Сургалтад хамрагдах багийн эмч нарын нэрсийг нэгдүгээр, гадаад сургалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Энэхүү гадаад сургалтыг хариуцлагатай зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
4. Гадаад сургалтад шаардагдах зардлыг энэ онд батлагдсан төгсөлтийн дараах сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



082035